

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/09/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт.....	
4.3 Албан шаардлага .....	17
4.4 Зөвлөмж .....	
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	Error! Bookmark not defined.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цэнцэргэвс бөг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ТҮМЭНБАЯР ТАНАА

2022.09.25 № 2/83  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Авлага, бараа материал, орлого үр дүнгийн тайланд орлого дутуу тусгасан, тайлант үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн, хүнсний болон бусад бараа материал, эмийн орлого зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, жилийн эцэст тооллого хийж тооцоо бодож баталгаажуулаагүй, НДШ, ХХОАТ-ын тайлан гаргалт хангалтгүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, Шилэн дансны хуульд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох

2021092505

төсөвт шилжүүлэх;". Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ;". 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;". 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх; 3/нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах;". Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2- д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа" 70.2.2-т " түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", "Үнэлгээ ба хуваарилалт", "голилуулга", "эрх ба үүрэг", "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>269,556,179.35</u>	<u>466,253,646.92</u>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	4,472.33
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	4,472.33
3121	<b>Төгрөг</b>	-	4,472.33
31211	Төрийн сангийн харилцах	-	4,472.33
33	<b>АВЛАГА</b>	19,119,100	194,282,054
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,074,925	12,319,014
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	166,830,310
335	<b>Бусад авлага</b>	15,044,175	15,132,730
3351	Байгууллагаас авах авлага	10,922,280	11,170,535
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,121,895	3,962,195
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	250,437,079.35	271,967,120.59
351	<b>Түүхий эд материал</b>	89,043,152.35	110,496,688.95
35110	Тусгай зориулалттай материал	5,155,250	9,793,478
35130	Эм боох материал	83,887,902.35	100,703,210.95
354	<b>Хангамжийн материал</b>	161,393,927	161,470,431.64
35410	Бичиг хэргийн материал	1,552,750	1,552,750
35420	Аж ахуйн материал	10,266,660	9,710,560
35440	Түлш, шатах тослох материал	129,543,958	125,410,958
35460	Хүнсний материал	14,782,940	16,363,440
35470	Бусад хангамжийн материал	5,247,619	8,432,723.64
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>7,308,359,412.64</u>	<u>7,392,786,797.80</u>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,308,359,412.64	7,392,786,797.80
392	<b>Биет хөрөнгө</b>	7,294,855,412.64	7,378,293,214.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,240,172,123	7,240,172,123
39202	Хуримтлагдсан элэгдэл	(354,662,529)	(529,529,265)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	135,449,054	135,449,054
39204	Хуримтлагдсан элэгдэл	(123,041,159.40)	(129,937,481.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,010,636,108	1,336,023,407.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(626,416,062.39)	(684,795,531.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,104,087	70,904,087
39208	Хуримтлагдсан элэгдэл	(56,386,208.57)	(59,993,178.19)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	13,504,000	14,493,583.35
39301	Программ хангамж	275,000	1,525,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000)	(535,416.65)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,504,000	13,504,000
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<u>7,577,915,591.99</u>	<u>7,859,040,444.72</u>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<u>2,971,327.37</u>	<u>245,975,672.80</u>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,971,327.37	245,975,672.80
413	<b>Өглөг</b>	2,971,327.37	245,975,672.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,110,596.61	91,182,329.12

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	149,209,089.92
4136	<b>Бусад өглөг</b>	1,860,730.76	5,584,253.76
41361	Байгууллагад төлөх өглөг	1,604,930.76	4,407,830.76
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	255,800.00	1,176,423.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,574,944,264.62</b>	<b>7,613,064,771.92</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,574,944,264.62</b>	<b>7,613,064,771.92</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470,965,819	470,965,819
51101	Өмч: - төрийн	470,965,819	470,965,819
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,919,680,198.25</b>	<b>6,957,800,705.55</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	6,919,680,198.25	6,919,680,198.25
51220	Тайлант үеийн үр дүн	-	38,120,507.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	184,298,247.37	184,298,247.37
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,577,915,591.99</b>	<b>7,859,040,444.72</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,014,299,181	2,187,383,676.90
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	166,060,357	394,900,087.40
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	166,060,357	394,900,087.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	166,060,357	19,423,874
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,668,873	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,423,874
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	152,391,484	-
120009	Бусад орлого	-	2,000,000
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		321,673,699.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		51,802,514.04
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,848,238,824	1,792,483,589.50
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,299,040,200	238,306,660
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,299,040,200	238,306,660
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,642,090	96,967,605
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,642,090	96,967,605
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	536,556,534	1,457,209,324.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	536,556,534	1,457,209,324.50
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	1,914,061,110.48	2,149,263,169.60
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,914,061,110.48	2,149,263,169.60
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,913,982,259.61	2,060,663,169.60
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,061,397,786.67	1,098,611,156.46
210101	Үндсэн цалин	1,046,856,779.67	550,423,286.18
210102	Нэмэгдэл	-	393,413,517.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	36,912,000.60
210104	Урамшуулал	14,541,007.00	117,862,352.52

2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	133,647,432.37	142,170,583.92
210201	Тэтгэврийн даатгал	133,647,432.37	87,791,244.99
210202	Тэтгэмжийн даатгал	-	23,004,902.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	8,396,622.97
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,926,744.41
210205	Эрүүл мэндийн даатгал	-	21,051,069.42
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	66,262,148.70	73,983,935.20
210301	Гэрэл, цахилгаан	29,236,098.80	25,375,935.20
210302	Түлш, халаалт	32,649,250.00	43,508,000
210303	Цэвэр, бохир ус	4,376,799.90	5,100,000
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	76,024,867	92,375,290.62
210401	Бичиг хэрэг	7,207,250	7,129,450
210402	Тээвэр, шатахуун	50,557,370	51,515,020
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,570,607	7,249,600.62
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,606,140	420,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,083,500	26,061,220
2105	<b>Нормативт зардал</b>	319,261,289.41	388,354,739.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	281,778,839.41	337,362,707.20
210502	Хоол, хүнс	30,546,450	50,992,032
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,936,000	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,189,200	9,311,800
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	7,407,000
210604	Урсгал засвар	5,189,200	1,904,800
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,274,000	1,515,000
210702	Дотоод албан томилолт	1,274,000	780,000
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	735,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,339,152	10,288,850
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,337,533	5,040,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	120,000
210803	Даатгалын үйлчилгээ	272,850	428,850
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,596,769	4,700,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	241,586,383.46	244,051,814.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	41,900
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	241,586,383.46	244,009,914.20
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	78,850.87	88,600,000
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	88,600,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	88,600,000
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	78,850.87	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	78,850.87	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<u>100,238,070.52</u>	<u>38,120,507.30</u>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	2,780,362.46	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,780,362.46	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(2,780,362.46)	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<u>97,457,708.06</u>	<u>38,120,507.30</u>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	470,965,819	184,298,247.37	6,819,635,145.19	7,474,899,211.56
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	470,965,819	184,298,247.37	6,819,635,145.19	7,474,899,211.56
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	98,357,708.06	98,357,708.06
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	470,965,819	184,298,247.37	6,917,992,853.25	7,573,256,919.62
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	470,965,819	184,298,247.37	6,917,992,853.25	7,573,256,919.62
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	470,965,819	184,298,247.37	6,917,992,853.25	7,573,256,919.62
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	38,120,507.30	38,120,507.30
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	470,965,819	184,298,247.37	6,956,113,360.55	7,611,377,426.92

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,862,807,697</b>	<b>1,647,091,476.50</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	14,568,873	21,423,874
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	14,568,873	21,423,874
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	13,668,873	19,423,874
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,668,873	19,423,874
120009	Бусад орлого	900,000	2,000,000
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,848,238,824.00	1,625,667,602.50
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,299,040,200	238,306,660
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,299,040,200	238,306,660
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,642,090	96,967,605
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,642,090	96,967,605
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	536,556,534	1,290,393,337.50
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	14,323
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	536,556,534	1,290,379,014.50
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,862,807,697.00</b>	<b>1,643,073,404.17</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,862,807,697.00	1,643,073,404.17
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,862,728,846.13	1,554,473,404.17
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,056,052,248.43	1,043,715,421.17
210101	Үндсэн цалин	888,848,527.33	516,979,757.85

210102	Нэмэгдэл	131,507,811.10	387,135,689.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,434,500	30,737,220.60
210104	Урамшуулал	24,261,410	108,862,752.98
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	137,710,764.90	113,667,486.87
210201	Тэтгэврийн даатгал	134,617,664.90	78,765,526.28
210202	Тэтгэмжийн даатгал	773,300	8,949,532.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	618,600	7,405,225.69
210204	Ажилгүйдлийн даатгал	154,700	1,925,136.81
210205	Эрүүл мэндийн даатгал	1,546,500	16,622,065.45
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	148,107,998.80	-
210301	Гэрэл, цахилгаан	33,716,098.80	-
210302	Түлш, халаалт	108,615,000	-
210303	Цэвэр, бохир ус	5,776,900	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	71,397,472	887,055.00
210401	Бичиг хэрэг	6,942,100	-
210402	Тээвэр, шатахуун	49,595,495	887,055.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,837,707	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,692,700	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,329,470	-
2105	<b>Нормативт зардал</b>	398,827,980	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	346,335,190	-
210502	Хоол, хүнс	41,501,090	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,991,700	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,498,000	2,089,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,368,500	1,830,000
210604	Урсгал засвар	4,129,500	259,000
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,482,300	7,134,150
210702	Дотоод албан томилолт	1,482,300	7,134,150
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,652,082	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,831,263	-
210803	Даатгалын үйлчилгээ	272,850	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,915,969	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,500,000	-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	386,980,291.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	386,980,291.13
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	78,850.87	88,600,000
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	88,600,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	88,600,000
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	78,850.87	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	78,850.87	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b> (3)=(1)-(2)	=	<u>4,018,072.33</u>

5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b> (5)	-	4,013,600
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	4,013,600
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	4,013,600
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	4,013,600
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<u>(4,013,600.00)</u>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	4,472.33
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	4,472.33

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,863,819,100	1,849,186,756.13	1,995,911,500	1,519,295,399.17
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,863,819,100	1,849,186,756.13	1,995,911,500	1,519,295,399.17
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,862,499,100	1,849,186,756.13	1,994,531,500	1,519,295,399.17
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,061,637,300	1,056,052,248.43	1,102,078,800	1,014,634,021.17
210101	Үндсэн цалин	556,286,400	553,430,270.43	602,243,600	516,979,757.85
210102	Нэмэгдэл	378,681,700	372,624,207	361,681,700	387,135,689.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,738,000	43,453,500	47,817,000	30,737,220.60
210104	Урамшуулал	80,931,200	86,544,271	90,336,500	79,781,352.98
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	138,765,300	137,710,764.90	148,780,700	113,667,486.87
210201	Тэтгэврийн даатгал	97,649,700	96,595,164.90	104,697,500	78,765,526.28
210202	Тэтгэмжийн даатгал	10,278,900	10,278,900	11,020,800	8,949,532.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,223,100	8,223,100	8,816,600	7,405,225.69
210204	Ажилгүйдлийн даатгал	2,055,800	2,055,800	2,204,200	1,925,136.81
210205	Эрүүл мэндийн даатгал	20,557,800	20,557,800	22,041,600	16,622,065.45
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	146,168,700	149,396,023.80	220,200,000	-
210301	Гэрэл, цахилгаан	31,760,500	33,716,098.80	52,800,000	-
210302	Түлш, халаалт	108,615,000	109,903,025	153,000,000	-
210303	Цэвэр, бохир ус	5,793,200	5,776,900	14,400,000	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	71,878,500	69,450,947	72,463,100	-
210401	Бичиг хэрэг	4,109,000	6,942,100	2,500,000	-
210402	Тээвэр, шатахуун	50,422,100	47,648,970	52,047,800	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,205,300	2,837,707	3,205,300	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,525,800	5,692,700	8,000,000	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,616,300	6,329,470	6,710,000	-
2105	<b>Нормативт зардал</b>	389,288,200	386,844,390	378,788,000	-

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	331,432,600	334,351,600	324,787,000	-
210502	Хоол, хүнс	45,104,600	41,501,090	41,250,000	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,751,000	10,991,700	12,751,000	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,019,300	26,598,000	21,192,500	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,970,300	22,468,500	16,143,500	-
210604	Урсгал засвар	5,049,000	4,129,500	5,049,000	-
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,500,000	1,482,300	3,500,000	-
210702	Дотоод албан томилолт	2,500,000	1,482,300	3,500,000	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	29,241,800	21,652,082	47,528,400	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,627,300	9,831,263	28,800,000	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000	-	450,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	272,900	272,850	1,247,400	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	712,800	-	712,800	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000	132,000	1,425,600	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,327,800	8,915,969	7,173,600	-
210807	Газрын төлбөр	120,000	-	120,000	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000	-	99,000	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,500,000	2,500,000	7,500,000	-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-	-	390,993,891.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	390,993,891.13
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,320,000	-	1,380,000	-
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,320,000	-	1,380,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,320,000	-	1,380,000	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,863,819,100	1,849,186,756.13	1,995,911,900	1,519,299,871.50
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,299,040,200	1,298,961,349.13	1,431,132,600	238,306,660
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,299,040,200	1,298,961,349.13	1,431,132,600	238,306,660
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	549,278,900	536,556,534	549,278,900	1,259,569,337.50
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-	-	14,323
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	549,278,900	536,556,534	549,278,900	1,259,555,014.50
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	15,500,000	13,668,873	15,500,400	19,423,874
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,500,000	13,668,873	15,500,400	19,423,874
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				2,000,000
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	4,472.33
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	1	1

610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	69	69	69	74
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	64	64	64	69
620003	Үйлчлэх ажилтан	4	4	4	4
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	69	69	69	86
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	50	50	50	55
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19	19	19

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	12,642,090	127,791,605
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	12,642,090	127,791,605
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	12,642,090	39,191,605
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	29,081,400
210104	Урамшуулал	-	29,081,400
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	658,500	887,055
210402	Тээвэр, шатахуун	658,500	887,055
2105	<b>Нормативт зардал</b>	11,983,590	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,983,590	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	2,089,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,830,000
210604	Урсгал засвар	-	259,000
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	-	7,134,150
210702	Дотоод албан томилолт	-	7,134,150
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	88,600,000
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	88,600,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	88,600,000
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	12,642,090	96,967,605
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,642,090	96,967,605
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,642,090	96,967,605

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын

талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 02 дугаар сарын 14-нөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Булган сумын Нэгдсэн эмнэлэг нь “Хүн амд ёс зүйг эрхэмлэсэн чадварлаг эмч мэргэжилтэн мэдлэг, дэвшилтэт технологид суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй хүргэх” гэсэн зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- *Сумын иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлэх,*
- *Хүн амд дотор, гэмтэл, мэс засал, уламжлалт, төрөх эмэгтэйчүүд, шүд, хүүхдийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг, нийгмийн эрүүл мэнд, амбулаторийн болон хэвтэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлэх,*
- *Үйлчлүүлэгчдэд тав тухтай орчин бий болгох,*
- *Лабораторийн тусламж үйлчилгээ*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*
- *Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн батлах,*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрүүл мэндийн яамны хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дотоод аудитын албанаас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Их” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2,187.4 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 21.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 14.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 281.1 сая төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өглөгийн данс байна.

Тайлант оны эхэнд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 4.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, төрийн санд байршиж байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл 19.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 194.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 172.2 сая төгрөгөөр өссөн байна. Эцсийн авлагын нийт үлдэгдэл 166.8 сая төгрөг буюу 95.2 хувийг ЭМД-ын сангаас ковид-19 санхүүжилт, 16.4 сая төгрөг нь ажиллагчидтай холбогдсон авлага буюу НДШимтгэл, ХХОАТ, илүү олгосон цалинтай холбоотой, 7.1 сая төгрөг нь сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор баруун 5 сумдад ажиллах томилолтын зардал, 4.0 сая төгрөг нь бусад тооцооны авлага байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 493.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 51.8 сая төгрөгөөр нийт 545.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 524.1 сая төгрөгийн материалыг зарцуулж оны эцэст 271.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 8,469.1 сая төгрөг байсан бол оны эцэст 8,797.6 сая төгрөг болж 328.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант онд 8.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 319.8 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, тайлант онд хөрөнгө акталж устгаагүй, тайлант оны эцэст 7,392.8 сая төгрөгийн цэвэр үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эхэнд эцэст 3.0 сая төгрөг байсан оны эцэст 245.9 сая төгрөгийн өр төлбөртэй байгаагаас НДШ-д 57.0, ХХОАТ-т 31.4, ҮЭ-д 1.6, нүүрсний өр 38.0, гэрэл цахилгааны зардалд- 11.5, бусад өглөг 6.4, санхүүгийн программ худалдан авсан төлбөр 1.3, эмийн өр 99.6 сая төгрөгийн төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 7,574.9 сая төгрөг байсан оны эцэст 7,613.1 сая төгрөг болж тайлант онд 38.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 6,957.8 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Булган сумын Нэгдсэн эмнэлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,921.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,921.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ховд аймгийн ТЕЗ-аас тус байгууллагын төсвийг 1,922.6 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 1,922.6 сая төгрөгийн төсөв баталснаас 335.2 сая төгрөгийг улсын төсвөөс, ЭМДС-аас 1,577.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 10.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 238.3, ЭМДС-аас 1,259.6, үндсэн үйл ажиллагааны орлогоос 19.4, төслийн сургалтын зардал 2.0 нийт 1,519.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,519.3 сая төгрөгийг зарцуулж 0.004 сая мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан төсөв хэрэгжсэнтэй холбоотойгоор 1,519.3 сая төгрөгийн төсвийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар ЭМДС-аас ковидын эмчилгээний зардал, улаан бүсэд ажилласан илүү цагийн зардалд 30.8, нэг удаагийн тэтгэмж 88.6, ЭМГ-аас сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх томилолт, шатахууны зардал 8.0, шинжилгээний орлого 0.4 сая 127.8 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Ковидын урамшууллыг тухайн үед ажиллаж байсан 72 эмч, мэргэжилтэн, ажилтанд 25.4 сая төгрөг олгожээ.

#### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, 105 мэдээллийг хугацаа хоцроосон, 36 мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг PDF хэлбэрээр оруулаагүй, хагас жилийн санхүүгийн тайлан мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 9, зарлагын 10 ажил гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 980.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 190.9 сая төгрөгийн залруулга, 30.6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 30.6 сая төгрөгийн албан шаардлага, 521.5 сая төгрөгийн 7 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд эмч ажилчдад олгосон, илүү цаг, улирлын мөнгөн урамшуулал олголт, алсын дуудлага болон жолоочийн тооцоо бодолт, бараа материалын зарцуулалт, цалин олголт, ковидын илүү цаг олголт зэрэг асуудлууд болон өмнөх дараагийн аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 214.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 50.8 сая төгрөгийн алдааг залруулж, 8.1 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 145.5 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 10.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлогыг 8.4 сая төгрөгөөр дутуу тусгасан,
2. Авлагыг 17.0 сая төгрөгөөр дутуу,
3. Өр төлбөрийг 7.0 сая төгрөгөөр дутуу
4. Тайлант үеийн үр дүнг 18.4 сая төгрөгөөр зөрүүтэй,

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 50.8 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дүгээр сарын 25-ны 26 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

## 4.2 Төлбөрийн акт

4.2.1 Эмч мэргэжилтэнд 7 дугаар сард 2 дугаар улирлын мөнгөн урамшуулал олгохдоо НДШимтгэлийг 3.7, ХХОАТ-ыг 2.8 сая төгрөгийг суутган тооцоогүй олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”, 17 дугаар зүйлийн 17.1-д “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:”, 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;”, 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх; 3/нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: төлбөрийн акт тогтоов.

4.2.2 2021 оны 7 дугаар сард мөнгөн урамшуулал олгохдоо илүү цагийн болон шөнийн нэмэгдэлд 1.6 сая төгрөгийг илүү тооцон олгосон дутагдал илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдөөгүй тул төлүүлэх төлбөрийн акт бичлээ.

Шийдвэрлэсэн: төлбөрийн акт тогтоов.

## 4.3 Албан шаардлага

4.3.1 Бараа материалын тайлан дахь хүнсний материалын зарлагын дүн сар, өдөр бүрээр бичсэн хоолны захиасны түүвэртэй тулгахад 9.5 сая төгрөгөөр зөрүүтэй, эмийн зарлагын түүвэр, санхүүгийн программ дах зарлагын түүвэр 6.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайлан дах тоо мэдээлэл бодитой үнэн илэрхийлснийг нотлох боломжгүй мөн хүнсний материал 13.9, аж ахуйн материал 1.3, эм ороох материал 3.7 сая төгрөгийн материалыг бодитой оршин байхгүй, өмнөх 2020 онд зарцуулаад зарцуулсан нь тодорхой бус байгаа нь дотоод хяналт хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

4.3.2 Үндсэн хөрөнгийн данс бүртгэлд байгаа хөрөнгүүд бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус сүүлийн жилүүдэд байгууллагын хөрөнгөд тооллого хийж тооцоо бодоогүй, ашиглалтын хугацаа дууссан ашиглагддаггүй 110.4 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлээгүй дутагдал байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д " төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70

дугаар зүйлийн 70.2- д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа” 70.2.2-т “ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/”, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна, гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: албан шаардлага өгөв

#### 4.4 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 4.4.1 **Анхан шатны баримттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Томилолтын мөнгө олгохдоо анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, томилолтын хуудсыг байгууллагын удирдлагаар хаалт хийлгээгүй, ирсэн буцсан өдөр засвартай баримтаар 2.9 сая төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гаргахгүй байх,

##### 4.4.2 **НДШ, ХХОАТ-тай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Нэгдсэн эмнэлгийн 2021 оны НДШ-ийн сар бүрийн тайлангийн цалингийн сан зөрүүтэй, ХХОАТ-ын тайлан дах тоо мэдээлэл зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрлээ

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Хувь хүний орлогын албан татварын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;", Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:", 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;", 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх; 3/нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах;" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, журамд заасны дагуу НДШ болон ХХОАТ-ын тооцоог дахин хийж тайланг үнэн зөв илгээж алдааг залруулан ажиллах

##### 4.4.3 **Дотоод хяналттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны А/17 тоот тушаалаар "Дотоод хяналтын баг" томилсон боловч хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгүй, ажлын тайлангүй байгаа нь дотоод хяналт хэрэгжээгүй байна.

Мөн тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч, нярав нар тайлант онд 2-3 удаа солигдсон тогтвор суурьшилтай ажилладаггүйгээс байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт сул, аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангагддаггүй, өмнөх илэрсэн зөрчлүүд давтан гарсаар байна.

**Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д "энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө", 3.5-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ", 3.6-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ" байгууллагын дотоод журмын 4-ийн 4.16-д "Байгууллага дотоод хяналт шалгалтыг хамт олны хурлаар хэлэлцэж, байгууллагын даргын тушаалаар батлагдсан /дотоод хяналт шалгалтын журмын дагуу зохион байгуулна. 4.17. Байгууллагын даргын шийдвэрээр орон тооны бус байнгын дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан томилно, гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн хамт олонд мэдээлэх,

#### 4.4.4 Эм ороох боох материалтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант оны эцэст 1.3 сая төгрөгийн хугацаа дууссан эм, 6.3 сая төгрөгийн жирэмслэлтээс хамгаалах эм тарианы үлдэгдэлтэй байгаа нь тооцоо судалгаагүй их хэмжээгээр худалдан авсан нь ажлын хариуцлага сул, санхүүгийн ажилтан болон дотоод хяналтын хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаагүй зөрчил илэрлээ.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах талаар анхааран ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая. төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын Нэгдсэн эмнэлэг	14	214.8	4	60.8	2	8.1	1	145.5	4	10.4

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

АХЛАХ АУДИТОР: Д.НАРАНТУУЛ

ТАЙЛАНГ БИЧСЭН

Аудитын код: ХОА-2022/09/НА-СТА-ТШЗ

17